



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өлгий сумын 2 дугаар Бүрэн дунд сургуулийн
2016 оны 12 дугаар сарын 31-нээр
дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан

Аудитын код: БӨА-2017/82/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: edu.bo.gov.mn

Тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 99417382 Цахим хаяг: mhkuangan@yahoo.com

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930, 98081144, 99932710 Цахим хаяг: kh_jenisbek@yahoo.com

Аудитор: Д.Назгүл

Утас: 99427301 Цахим хаяг: nazgul_1972@yahoo.com

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.12	Шилэн дансны мэдээлэл	10
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
3.1	«management_zurchil1»	Error! Bookmark not defined.
3.2	«management_zurchil2»	Error! Bookmark not defined.
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..	Error! Bookmark not defined.
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21

1 Аудитын гэрчилгээ



Г ӨЛГИЙ СУМЫН 2 ДУГААР БҮРЭН ДУНД
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
М.АДИЛБИШ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий сум, Баян-Өлгий аймаг,

Утас/факс: (976) 7042-2954

E-mail: bayanulgii@audit.gov.mn

6017.02.12 № 10 ӨМ. 6017/02.12-10.3
танай _____-ны № _____-□

Г Аудитын гэрчилгээ Г

Өлгий сумын 2 дугаар Бүрэн дунд сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу Баян-Өлгий аймгийн Аудитын газраас аудит хийв.

Төсвийн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Өлгий сумын 2 дугаар Бүрэн дунд сургуулийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулга материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Gershilgee.doc

Зөрчилгүй санал дүгнэлт

Өлгий сумын 2 дугаар Бүрэн дунд сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Өлгий сумын 2 бүрэн дунд сургуулийн захирал М.Адилбиш танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Өлгий сумын 2 дугаар бүрэн дунд сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Өлгий сумын 2 дугаар бүрэн дунд сургуулийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.02.09-наас 2017.02.13-ны хооронд хийж, аудитын тайланг 2017.02.13-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, аймгийн Аудитын газрын аудитор Д.Назгүл хариуцаж хэрэгжүүлэв.

Өлгий сумын 2 дугаар бүрэн дунд сургуулийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017.01.20-нд төрийн аудитын байгууллагад 2017.01.20-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Өлгий сумын 2 дугаар бүрэн дунд сургууль “Суралцагчдын хэрэгцээнд суурилсан хүртээмжтэй, сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан зөв хандлага төлөвшилтэй, бүтээлч, бие даан сурах хүсэл тэмүүлэлтэй хүүхдүүдийг бэлтгэх, хүүхдүүдийг сурган хүмүүжүүлэх, боловсрол эзэмшүүлэх” эрхэм зорилготой ба тайлант онд дараахь зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.Үүнд:

“Зорилго1 : Багш хүүхэд нэг бүрийг хөгжүүлж нээлттэй уян хатан үйлчилгээтэй “Бүтээлч, тэргүүний хамт олон” болгох

Зорилт-2:Сургалтын үр дүнг үнэлж тооцон, үр дүнд суурилсан хяналт, үнэлгээний систем нэвтрүүлэх

Зорилт-3:Хүүхэд бүрийг төлөвшүүлэх, хөгжүүлэх хүүхэд хөгжлийн төв болно.

Зорилт-4:Нийгэм сэтгэл зүй, дээд бүтцийн эрүүл аюулгүй, ээлтэй орчин, сурах, амьдрах, стандарт шаардлага хангасан нийгмийн үйлчилгээг бий болгоно.

Зорилт-5: Сургууль байгуулагдсаны түүхт 90 жилийн ойг угтсан үйл

ажиллагаараа бүтээлч сэтгэлгээтэй, эерэг хандлагатай, амьдрах ухаантай багш, сурагчид болно” дэвшүүлэн ажиллажээ.

Өлгий сумын 2 дугаар бүрэн дунд сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Өлгий сумын 2 дугаар бүрэн дунд сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Өлгий сумын 2 дугаар бүрэн дунд сургуулийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Өлгий сумын 2 дугаар бүрэн дунд сургуулийн санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Accolous” програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Өлгий сумын 2 дугаар бүрэн дунд сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн

тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 15 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 1 асуудал эрсдэл өндөр, 2 асуудал эрсдэл дунд, 0 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 9 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 1 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн Нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн шатанд сонгосонтой холбоотой юм.

Өлгий сумын 2 дугаар бүрэн дунд сургуулийн 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1.5 тэрбум төгрөг бөгөөд түүний 1 хувь 14,9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь – төлөвлөлтийн шатанд 1 хувиар төлөвлөсөнтэй холбоотой.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 4 чиглэлээр 38 эрсдэлтэй асуудалд 38 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 25 хувь буюу 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)				
№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	1	0.0	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	0.4	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	2	0.4	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, ГАРГАСАН ШИЙДЭЛ

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

2.9.1.1 Аудитаар Засгийн газрын 2012 оны 106 тоот тогтоолын 1-д Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдийн үдийн цайны зардлыг 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 600 төгрөгөөр тогтоосон заалт болон Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчиж гүйцэтгэлээрх хүүхдийн тооноос илүү санхүүжилт олгосон нь тогтоогдсог тул Үдийн цайны зардалд илүү олгосон 404,0 мянган төгрөгийн санхүүжилтийг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Албан шаардлага өгөгдөөгүй.

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сахилгын шийтгэл ногдуулах алдаа, зөрчил илэрээгүй.

2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх алдаа, зөрчил илэрээгүй.

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Сургуулийн бүтэц, орон тооны асуудлыг дараагийн аудитаар анхаарч үзэж шаардлагатай байна.

2.11 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Өлгий сумын 2 дугаар бүрэн дунд сургуулийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 1390,2 сая төгрөгийн, хөрөнгийн зардалд 0 төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1390,2	1425,2	2,5%	34,9
1.1	Урсгал зардал	1390,2	1425,24	2,5%	34,9
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0	0.0%	0.0
2	Зардлыг сахуужүүлэх эх үүсвэр	1390,2	1425,2	2,5%	34,9
2.1	Улсын төсвөөс санхүүжих	1390,0	1425,1	2,5%	35,1
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	0,2	0,02	87%	-0,17

Төсөвт зардлын гүйцэтгэл 2,5 хувь буюу 34,9 сая төгрөгөөр хэтэрсэн дүнтэй байгаа нь өмнөх оны өр болох 35,1 сая төгрөгийн санхүүжилтийг тайлант жилд нэмж олгосонтой холбоотой байна.

Тайлант хугацаанд төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын биелэлт 17 хувь буюу төлөвлөгөө 83%-иар тасалдсан дүнтэй байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 4,8 сая төгрөг зарцуулсны дотор урсгал зардалд 4,8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Өлгий сумын 2 дугаар бүрэн дунд сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад 38 эрсдэлтэй асуудал тогтоогдож, 38 горим сорил хэрэгжүүлэв. Шилэн дансны мэдээллийг сар бүр тогтмол оруулж хэвшсэн байна.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх онд Өлгий сумын 2 дугаар Бүрэн дунд сургуульд итгэл үзүүлсэн байна.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Өлгий сумын 2 дугаар бүрэн дунд сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Өлгий сумын 2 дугаар бүрэн дунд сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

Асуудал 1: Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Тэргүүлэх ач холбогдол №1

Илрүүлэлт

Батлагдсан орон тоог 10 хүнээр хэтрүүлж Төсвийн тухай хуулийн 6.4.1-т заасан "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэснийг мөрдөж, төсвийг хэмнэлттэй зарцуулах гэснийг тус тус зөрчсөн байна.

Зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6.4.1-т заасан "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэснийг мөрдөж, төсвийг хэмнэлттэй зарцуулах;

Эрсдэл

Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах /Үнэн зөв байдал/

Төсвийн захирагчийн хариу

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн ба холбогдох саналаа ирүүлсэн.

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ
ӨЛГИЙ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
2 ДУГААР БҮРЭН ДУНД СУРГУУЛЬ
83129 Баян-Өлгий аймаг, Өлгий сум,
Утас: 7042-2625
E-mail: 2r.buren.dund.surguuli@gmail.com
2017.02.13 № 20
танай _____-ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

2016 оны төсөв 98 орон тоотой батлагдсан ба гүйцэтгэлээр 108 хүн ажилласан нь цөм хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбогдуулан БСШУ-ны сайд Нийгмийн хамгаалал, хөдөлмөр, Сангийн сайдын 307/91/237 дугаар тушаалын дагуу англи хэл, орос хэл, мэдээлэл зүйн хичээлүүдийг дэд бүлгээр 2016 оны БСШУ-ны сайдын А/275 дугаар тушаалын дагуу сонгон суралцах хичээлээр монгол хэл, математик, физик, нийгмийн ухаан, англи хэлний хичээлийг дэд бүлгээр тус тус заах 10 багшийн орон тоо нэмэгдүүлсэнтэй холбоотой юм.

Жилийн эцэст цалингийн сан 10,000,000 /арван сая/ төгрөгөөр дутсаныг Төрийн сангаас зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулалтаар зөвшөөрөл авч, өрийг хаасан болно.

Цаашид батлагдсан төсөвт багтаан, үйл ажиллагаагаа явуулж болно.

ЗАХИРАЛ  М.АДИЛБИШ



Albanbicheg 2017

4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10793271.00	14105460.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
33	АВЛАГА	1023324.00	1263973.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		
33300	Татаас, санхүүжилтийн авлага		
33400	Зээлийн хүүгийн авлага		
33401	Дансны авлага /ТӨҮГ/		
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/		
335	Бусад авлага	1023324.00	1263973.00
3351	Байгууллагаас авах авлага		
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1023324.00	1263973.00
35	БАРАА МАТЕРИАЛ	9769947.00	12841487.00
351	Түүхий эд материал	139700.00	82000.00
35110	Тусгай зориулалттай материал		
35130	Эм боох материал	139700.00	82000.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
354	Хангамжийн материал	9630247.00	12759487.00
35410	Бичиг хэргийн материал	1764312.00	1683580.00
35420	Аж ахуйн материал	157700.00	263950.00
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал		
35450	Барилгын засварын материал	476795.00	781845.00
35460	Хүнсний материал		
35470	Бусад хангамжийн материал	7231440.00	10030112.00
35500	Биологийн хөрөнгө		
35600	Мал амьтад		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2712739277.90	3377260413.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2712739277.90	3377260413.07
391	Газар		

Өлгий сумын 2 дугаар Бүрэн дунд сургуулийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

392	Биет хөрөнгө	2712739277.90	3377260413.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	844826036.00	844826036.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-501714523.87	-521147746.03
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2500000.00	2500000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-2500000.00	-2500000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	222094141.00	223174696.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	-91825056.31	-121791740.11
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	161769210.00	190467823.75
39208	Хуримтлагдсан элэгдэл	-50640364.46	-65287584.34
39214	Бусад үндсэн хөрөнгө	33213291.00	33213291.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-17224812.71	-21096517.79
39216	Дуусаагүй барилга, байгууламж	2025700000.00	2725699300.00
39217	Ном	86541357.25	89202854.44
393	Биет бус хөрөнгө	0.00	0.00
39301	Програм хангамж	1782150.00	1782150.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1782150.00	-1782150.00
39303	Бусад биет бус хөрөнгө		
39304	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2723532548.90	3391365873.07
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	35131750.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	35131750.00	0.00
413	Өглөг	35131750.00	0.00
4136	Бусад өглөг	35131750.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	35131750.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2688400798.90	3391365873.07
51	Засгийн газрын хувь оролцоо	2688400798.90	3391365873.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	468383260.45	468383260.45
51101	Өмч: - төрийн	468383260.45	468383260.45
512	Хуримтлагдсан үр дүн	1883283605.12	2586248679.29
51210	Өмнөх үеийн үр дүн	1883283605.12	1883283605.12
51220	Тайлант үеийн үр дүн		702965074.17
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	336733933.33	336733933.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2723532548.90	3391365873.07

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2351583686.18	2197553639.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1417199258.18	1457647001.09
120	Нийтлэг татварын бус орлого	125173558.18	32496701.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	125173558.18	32496701.09
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		26035.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	125173558.18	32470666.09
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1292025700.00	1425150300.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1292025700.00	1425150300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	934384428.00	739906638.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	924737650.00	699999300.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	924737650.00	699999300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	215000.00	4800000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	215000.00	4800000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9431778.00	35107338.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	9431778.00	35107338.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих		
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1385057860.70	1494588564.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1385057860.70	1494588564.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1239682182.70	1288339750.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	897659627.00	929319603.00
210101	Үндсэн цалин	831289669.00	856516303.00
210104	Урамшуулал	62644258.00	68850000.00
210105	Гэрээт ажлын хөлс	3725700.00	3953300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98644549.00	103153404.00
210201	Тэтгэврийн даатгал	62773802.00	60586145.00
210202	Тэтгэмжийн даатгал	7174149.00	12544016.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8967688.00	9382323.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1793538.00	1876383.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17935372.00	18764537.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	175707857.00	164996057.00
210301	Гэрэл, цахилгаан	1662646.00	1557154.00
210302	Түлш, халаалт	171838047.00	160869573.00

Өлгий сумын 2 дугаар Бүрэн дунд сургуулийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

210303	Цэвэр, бохир ус	2207164.00	2569330.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3852643.00	5059596.00
210401	Бичиг хэрэг	990140.00	828282.00
210402	Тээвэр, шатахуун	188277.00	437500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	630116.00	930596.00
210404	Ном, хэвлэл	1354110.00	1156278.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	690000.00	1706940.00
2105	Нормативт зардал	992900.00	1285970.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	70000.00	349200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	922900.00	936770.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3785800.00	2662150.00
210604	Урсгал засвар	3785800.00	2662150.00
2107	Томилолт, зочны зардал	1107000.00	585900.00
210702	Дотоод албан томилолт	1107000.00	585900.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1893732.20	1921900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1293732.20	1321900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600000.00	600000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56038074.50	79355170.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		312400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8476764.00	11123940.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47561310.50	67918830.92
210904	Найдваргүй авлагын алдагдал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	145375678.00	206248814.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	145375678.00	206032338.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	9431778.00	35107338.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	74478100.00	75652300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31711300.00	71897300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29135500.00	22660700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	619000.00	714700.00
213404	Хөрөнгийн		
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	216476.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		216476.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	966525825.48	702965074.17
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	0.00	0.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	55191.47	0.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	55191.47	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-55191.47	0.00

5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>966470634.01</u>	<u>702965074.17</u>
---	-------------------------	---------------------	---------------------

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1301672478.00	1465083673.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1292025700.00	1425176335.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	26035.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	26035.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		26035.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1292025700.00	1425150300.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1292025700.00	1425150300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9646778.00	39907338.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	215000.00	4800000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	215000.00	4800000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	9431778.00	35107338.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	9431778.00	35107338.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1302071510.20	1464993673.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1302071510.20	1464993673.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1163510732.20	1257804359.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	898338100.00	930094135.00
210101	Үндсэн цалин	831972200.00	857264800.00
210104	Урамшуулал	62640200.00	68876035.00
210105	Гэрээт ажлын хөлс	3725700.00	3953300.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98989400.00	101407900.00
210201	Тэтгэврийн даатгал	62993256.00	64513552.00
210202	Тэтгэмжийн даатгал	7199229.00	7378893.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8999036.00	9223639.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1799806.00	1844643.00
210205	Эрүүл мэндийн даатгал	17998073.00	18447173.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	147391007.00	164922928.00
210301	Гэрэл, цахилгаан	1662646.00	1557154.00
210302	Түлш, халаалт	143521197.00	160796444.00

Өлгий сумын 2 дугаар Бүрэн дунд сургуулийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

210303	Цэвэр, бохир ус	2207164.00	2569330.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4032493.00	5909396.00
210401	Бичиг хэрэг	261900.00	689800.00
210402	Тээвэр, шатахуун	188277.00	437500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	630116.00	930596.00
210404	Ном, хэвлэл	1973400.00	1486600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	978800.00	2364900.00
2105	Нормативт зардал	267500.00	2256500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	107700.00	285800.00
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	159800.00	1970700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3168000.00	2788600.00
210604	Урсгал засвар	3168000.00	2788600.00
2107	Томилолт, зочны зардал	1107000.00	591200.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	1107000.00	591200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1568132.20	1785400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	968132.20	1185400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600000.00	600000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8649100.00	48048300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		35328900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8649100.00	12719400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	138560778.00	207189314.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	138560778.00	206972838.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	9431778.00	35107338.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	67663200.00	76598000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31711300.00	71897300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	29135500.00	22660700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	619000.00	709500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	216476.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		216476.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-399032.20	90000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	441000.00	90000.00

Өлгий сумын 2 дугаар Бүрэн дунд сургуулийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	441000.00	90000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	441000.00	90000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	441000.00	90000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-441000.00	-90000.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-840032.20	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	840032.20	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4 АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	468,383,260.45	336,733,933.33	1,883,283,605.12		2,688,400,798.90
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	468,383,260.45	336,733,933.33	1,883,283,605.12	0.00	2,688,400,798.90
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	468,383,260.45	336,733,933.33	1,883,283,605.12	0.00	2,688,400,798.90
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	468,383,260.45	336,733,933.33	1,883,283,605.12	0.00	2,688,400,798.90
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	468,383,260.45	336,733,933.33	1,883,283,605.12	0.00	2,688,400,798.90
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			702,965,074.17		702,965,074.17
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	468,383,260.45	336,733,933.33	2,586,248,679.29	0.00	3,391,365,873.07

4.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1390218500.00	1390044535.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1390218500.00	1390044535.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1214853000.00	1218179035.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	921892400.00	930094135.00
210101	Үндсэн цалин	849089100.00	857264800.00
210102	Нэмэгдэл		
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	68850000.00	68876035.00
210105	Гэрээт ажлын хөлс	3953300.00	3953300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101407900.00	101407900.00
210201	Тэтгэврийн даатгал	64513552.00	64513552.00
210202	Тэтгэмжийн даатгал	7378893.00	7378893.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9223639.00	9223639.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1844643.00	1844643.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18447173.00	18447173.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	168615000.00	164922928.00
210301	Гэрэл, цахилгаан	3374500.00	1557154.00
210302	Түлш, халаалт	160796500.00	160796444.00
210303	Цэвэр, бохир ус	4444000.00	2569330.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	7199500.00	5999396.00
210401	Бичиг хэрэг	689800.00	689800.00
210402	Тээвэр, шатахуун	437500.00	437500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2130700.00	930596.00
210404	Ном, хэвлэл	1576600.00	1576600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2364900.00	2364900.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	2256500.00	2256500.00

Өлгий сумын 2 дугаар Бүрэн дунд сургуулийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	285800.00	285800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1970700.00	1970700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2788600.00	2788600.00
210604	Урсгал засвар	2788600.00	2788600.00
2107	Томилолт, зочны зардал	591200.00	591200.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	591200.00	591200.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1785400.00	2001876.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1185400.00	1185400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600000.00	600000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		216476.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8316500.00	8116500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	197100.00	197100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8119400.00	7919400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	175365500.00	171865500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	175365500.00	171865500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	80098000.00	76598000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	71897300.00	71897300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22660700.00	22660700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	709500.00	709500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1390218500.00	1390044535.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1390018500.00	1390018500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1390018500.00	1390018500.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	200000.00	26035.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200000.00	26035.00
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага		

Өлгий сумын 2 дугаар Бүрэн дунд сургуулийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	98.00	108.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	77.00	87.00
620003	Үйлчлэх ажилтан	19.00	19.00
620004	Гэрээт ажилтан	1.00	1.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	0.00	1464.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	0.00	1464.00
630001	Төрийн өмчит ЕБС		1464.00
630002	Хувийн ЕБС		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	0.0	108.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)		1.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)		106.00
650010	Гэрээт ажилтан		1.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)		

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Д.НАЗГҮЛ

Огноо: 2017.02.13